

МОНГОЛ УЛС БОЛОН ОХУ-ЫН БН САХА (ЯКУТ) УЛС ХООРОНДЫН ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ТУХАЙ

*М.Татьяна**

Бүгд Найрамдах Саха (Якут) Улс нь ЗХУ задарсаны дараа 1991 оны 10 дугаар сард шинээр байгуулагдаж, анхны Ерөнхийлөгчөөр нь Михаил Ефимович Николаев сонгогдсон. Энэ үед Бүгд Найрамдах улсынхаа нэрийг Саха гэсэн уламжлалт нэрээр сэргээсэн онцлогтой ба улсын хурлаа Ил Түмэн гэж нэрлэдэг болсон. 2002 оны ОХУ-ын нийт хүн амын тооллогоор Сахагийн хүн ам нь 949280 мянгад хүрч,¹ үүнээс 365 мянга нь якут үндэстэн. ОХУ-д нийт 382 мянган якут үндэстэн оршин суудаг.² Хүн амын дийлэнх нь христын үнэн алдартан болон бөөгийн шашин шүтдэг.

1992 оны 3-р сарын 31-ний өдөр гарсан Орос улс болон Холбооны субъектуудын хоорондын эрхлэх асуудлыг зааглах болон тэдгээрийн бүрэн эрхийн тухай холбооны гэрээ³ нь Оросын бүх субъектуудын гадаад харилцааг хөгжүүлэх улс төр-хууль, эрх зүйн үндэс болж өгсөн. Үүний дагуу ОХУ-ын Бүгд найрамдах улсуудыг "...олон улсын болон гадаад худалдаа, эдийн засгийн харилцааны бие даасан оролцогч..." хэмээн тодорхойлсон юм.⁴

Сахагийн гадаад харилцааг авч үзвэл 2 үндсэн үе шаттай. Эхний үе буюу 1-р үе шат нь (1991 хавар-1992 өвөл) хамгийн богино боловч маш чухал гэж үздэг. Энэ үе нь Саха улс нь ОХУ-ын Гадаад хэргийн яам, Гадаад худалдаа, эдийн засгийн хөгжлийн яамтай (ГХЭЗХЯ) шинээр тус тус холбоо байгуулж бэхжүүлэх явдал хийгээд олон улсын хамтын ажиллагааны бие даасан оролцогч болохыг эрмэлзэж байсан үе байв. Хамгийн анх Латви улс, Монгол Улстай худалдаа эдийн засгийн хамтын ажиллагааны Засгийн газрын хэлэлцээр байгуулсан нь Саха улсыг олон улсын болон гадаад худалдаа, эдийн засгийн харилцааны бие даасан оролцогч болсон гэж хүлээн зөвшөөрсөн явдал болсон.

Ингэснээр Саха улсын ГХЯ нь ОХУ-ын ГХЯ, ГХЭЗХЯ-тай тус тус протоколд гарын үсэг зурсан. Энэ нь гадаад харилцааны салбарт тус улс, холбооны байгууллагууд эрх тэгш оролцдог болсоны тодорхой илэрхийлэл хэмээн тэмдэглэв.

Үүний дараа II үе шатанд ОХУ болон БН Саха У-ын төрийн эрх бүхий байгууллагуудын хоорондох харилцан эрхлэх асуудлыг зааглах тухай гэрээ⁵ нь ОХУ болон БН Саха У-ын "Гадаад харилцаа, гадаад худалдаа,

* М.Татьяна - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ажилтан, магистр

эдийн засгийн салбарт эрхлэх асуудлыг зааглах болон тэдгээрийн бүрэн эрхийн тухай Хэлэлцээрт”⁶ гарын үсэг зурсан явдал болов.

1993 онд ОХУ-ын ГХЯ-ны дэргэд Холбооны субъект, парламент, нийгэм-улс төрийн байгууллагуудтай харьцах Ерөнхий газар⁷ болон ГХЭЗХЯ-ны дэргэд Холбооны субъект хоорондын гадаад худалдаа, эдийн засгийн үйл ажиллагааг зохицуулах ерөнхий газар⁸ байгуулагдсаны дараа Саха улсын ГХЯ эдгээр байгууллагуудтай ажил хэргийн холбоо барихад улам дөхөм болсон гэж үздэг. Холбооны яамдтай хэлэлцэх гол асуудал нь ОХУ-ын гадаад харилцаа, гадаад худалдаа, эдийн засгийн асуудал хэлэлцэхэд Саха улсын ашиг сонирхолд шууд хамаатай, нөлөөлөх асуудалд түүний төлөөлөгчид хамтран оролцох явдал юм.

ГХЯ тус улсыг олон улсын тавцанд эрх тэгш оролцогч болгон, гадаад харилцааг зохион байгуулан хөгжүүлэх үүргийг гүйцэтгэж байна.

1999 оны 11-р сарын 5-ны өдөр Саха улсын ерөнхийлөгчийн баталсан “Саха улсын олон улсын болон гадаад худалдаа, эдийн засгийн үйл ажиллагааны нэгдсэн стратеги хэрэгжүүлэхэд ГХЯ-ны үүрэг роль” тушаалын дагуу тус яам нь гадаад харилцаа, үйл ажиллагааг удирдах, зохицуулах эрх бүхий байгууллага нь болжээ.

Тус яамны гол зорилго нь Саха улсын нийгмийн шинэчлэлт өөрчлөлтөд эрчимтэй тусалцаа үзүүлэх, зах зээлийн хүчтэй эдийн засаг бий болгох, экспортын чиглэлтэй бүтээгдэхүүн нэмэгдүүлэхэд оршино. Үүнд олон улсын чанартай бүтээгдэхүүн бий болгохын тулд шинжлэх ухааны үндэслэлтэй хөтөлбөр хэрэгжүүлэх нь зөв гэж үзсэн байна.

1993 оны 4-р сарын 21-ний өдөр “...худалдаа, эдийн засаг, соёлын хамтын ажиллагааг эрх тэгш, харилцан ашигтай, нээлттэй байх зарчмын үндсэн дээр өргөжүүлэн хөгжүүлэхийг эрмэлзэн Саха улс нь ОХУ-ын бүрэлдэхүүн дэх Бүгд найрамдах улс мөнийг” эш үндэс болгон, Монгол Улс, ОХУ-ын хооронд найрамдал харилцаа, хамтын ажиллагааны тухай 1993 оны 1 дүгээр сарын 20-ны өдрийн гэрээг үндэслэн Эдийн засаг, шинжлэх ухаан, соёлын салбарт хамтран ажиллах тухай Монгол Улсын Засгийн газар болон ОХУ-ын БН Саха (Якут) Улсын Засгийн газар хоорондын Хэлэлцээрт гарын үсэг зурав.

Өнөөдөр Саха улс нь хэдэн арван улстай бие даан харилцдаг бөгөөд олон улсын байгууллагуудтай өргөн хамтран ажиллаж байна. Үүнд: ЮНЕСКО, Умардын Форум (Northern Forum), Зүүн Хойт Азийн бүс нутгуудын захиргаануудын холбоо (The Association of North East Asia Regional Governments-NEAR), Дэлхийн эрүүл мэндийн байгууллага, Олон улсын хөдөлмөрийн байгууллага, НҮБ-ын хөгжлийн хөтөлбөр

(UNDP). Мөн төлөөлөгчийн газруудаа Казахстан, Украин, Япон, Канадад нээн ажиллуулж байна. 2003 оны 9-р сард “Саха улсын үнэт металл болон үнэт чулууны асуудал эрхлэх хороо”⁹ нь БНХАУ-ын Шанхай хотод төлөөлөгчийн газраа нээсэн.

Холбооны Эдийн засаг, урьдчилсан төлөвлөгөөний яам болон Бүс нутгийн эдийн засгийн институттай хамтран Саха улс нь эдийн засгийн экспортын чиглэлтэй салбаруудыг хөгжүүлэх үзэл баримтлал, АНДБ-ийн орнуудад Саха улсын гадаад худалдаа, эдийн засгийн потенциалыг хэрэгжүүлэх хөтөлбөр тус бүр баталсан.

Саха улсын ГХЯ нь умард болон дорнод гэсэн хоёр үндсэн гол чиглэл баримтладаг. Энэ нь тус улсын зүүн хойд зүгт оршдог геополитикийн онцгой байршилтай холбоотой юм.

I. Умард чиглэл нь тус бүсэд олон талын хамтын ажиллагаа явуулж Умардын чуулганд (Northern Forum) 10 орны хамт оролцдог. Анх 1990 онд Анкоридж хотод (Аляска, АНУ) тус бүсийн олон улсын хурал болж, 1991 оны 11-р сард Умардын чуулган байгуулагдсан. Үүнд Финляндын Лапланди муж, Шведийн Вастерботтен, Норрботтен 2 вант улс, Хойд Норвегийн бүсийн удирдах газар, АНУ-ын Аляска муж, Канадын Альберта, Юкон болон баруун-хойд нутаг, Японы Хоккайдо муж, Хятадын Хармөрөн муж, ОХУ-ын БН Коми Улс, Саха Улс, Архангельская, Магаданская, Камчатская, Сахалинская мужууд, Ханты-Мансийский, Ненецкий, Эвенкийский, Ямало-ненецкий автономит тойрогууд, Санкт-Петербург хот болон Монгол Улсын Дорнод аймаг орж, нийт 10 орны 26 захиргааны нэгж, мөн Хойд Америк, Финляндын 20 бизнес-партнер оролцсон. Үүний дагуу: “Умард далайн зам”, “Баруун-зүүн болон циркумполяр агаарын шугам”, “Зэрлэг онгон байгалийг удирдах”, “Далайн баялгийг удирдах”, “Орчин тойрны мониторинг”, “Бореал ойг хадгалах” төслүүд хэрэгжиж байгаа бөгөөд “Арктикийн бүтээн байгуулалт, хөгжлийн банк”, “Умардын Форумын Шинжлэх Ухааны Академи” байгуулах тухай саналууд тавигдсан байна. Умард, Арктикийн ирээдүй нь хүн төрөлхтний иргэншлийн ирээдүй хувь заяатай шууд холбоотой бөгөөд дэлхийн нийгэмд тусгай нөөцтэй бүс гэж тооцогддог. Дэлхийн бусад тивүүдээс Арктик нь хүн төрөлхтөний иргэншлийн ирээдүйн байгалийн бааз манай гаригийн биосфер тогтоох хүчтэй хүчин зүйл мөн. Иймээс энд ганц умардын биш олон улс гүрнүүдийн ашиг сонирхол нийлдэг. ОХУ-ын умард газарт тус улсын газрын тосны 65, байгалийн хийн 85, нүүрсний 63, никелийн 90, ой модны 67, загасны 87, апатит, алмазын 95 хувь бас алт, мөнгө, олово,

ховор металл их бий. ОХУ-ын хүн амын дөнгөж 8 хувийг хэдийгээр эзэлдэг ч нийт улсын ҮНБ-ний 20 хувийг энд үйлдвэрлэж байна. “Умард далайн зам” ашигласнаар Номхон далай, Атлантын далайн хооронд хамгийн богино усан зам нээгдэж, энэ нь ОХУ-д төдийгүй АНУ, Канад, Япон, Их Британи, Норвеги, Швед, Финляндад маш их ашигтай байх болно гэсэн тооцоо хийгдсэн байна. “Баруун-зүүн болон циркумпольяр агаарын шугам” төслийн хүрээнд 1994 онд Арктикийн бүх газраар анх удаа нислэг хийсэн. 2002 оны байдлаар, Арктикийн трассыг ашиглан 5 агаарын компани байнгын кроссполяр чиглэлээр Хойд Америкаас Зүүн-Өмнөд Ази руу нислэг хийж байна. 2000 онд нийт 230 нислэг хийсэн бол 2001 онд 450-д хүрчээ. ОХУ-ын Засгийн газар Тээврийн бодлогын комиссын шийдвэрээр холбооны агаарын кроссполяр маршрутыг 10 жилийн хугацаанд хэрэгжүүлэх холбооны хөтөлбөр боловсруулсан. Энэ нь Оросын төсөвт урьдчилсан төлөвлөгөөгөөр нэг жилд 180 сая долларын ашиг оруулах юм байна. 2005 оны 6-р сард Харбинд болсон Умардын Форумын VII Ерөнхий Ассамблейн хурал дээр 2005-2007 онд тус байгууллагын даргаар Ханты-Мансийн автономит тойрог Югры-н Засгийн газрын дарга, амбан захирагч Александр Филипенко олонхи гишүүдийн саналаар сонгогдсон. Өмнө нь Финляндийн Лапландия мужийн дарга Ханнэле Покка 2001-2005 онд энэ албыг хашиж байжээ. Югры нь тус байгууллагад 1994 оноос эхлээд гишүүн болон оролцож байна.

Мөн Арктикийн Зөвлөлд (Arctic Council) Саха улс идэвхтэй оролцож байна. Тус зөвлөл нь 1996 оны 9-р сард Канадын Оттава хотноо АНУ, Канад, Исланд, Швед, Норвеги, Дани, Финлянд, ОХУ болон Арктикийн 8 улсын уулзалтын үр дүнд байгуулагджээ. Анх 1989 онд Финляндын санаачлагаар Арктикийн 8 орнуудын уулзалт болж, дараагаар 1991 онд АНУ, Канад, Исланд, Швед, Норвеги, Дани, Финлянд, ОХУ болон Арктикийн 8 улсын байгаль орчны яамдын сайд нарын хэмжээнд уулзалт Рованиеми хотод болсон уулзалтын үр дүнд Арктикт байгаль орчныг хамгаалах тунхаглал (Rovaniemi Declaration) баталж, мөн Арктикт байгаль орчныг хамгаалах стратеги (AEPS) боловсруулсан. Сайд нарын хэмжээнд жил бүр уулздаг. 1990 онд Арктикийн олон улсын шинжлэх ухааны хороо (International Arctic Science Committee, IASC) байгуулав. Тус байгууллагад Саха улсын төлөөлөгчид ОХУ-ын бүрэлдэхүүнд багтан оролцдог. Арктикийн зөвлөлийн гол зорилго нь тогтвортой эдийн засаг болон нийгмийн хөгжил, хүн ам, эрүүл мэнд, соёл, байгаль орчныг хамгаалахад оршино.

Саха улс нь Умардад олон талын хамтын ажиллагаа явуулахад үе шатчилсан тууштай санал дэвшүүлсэн:

1. Тус бүс нутгийн улс төрийн хэрэгсэл нь Арктикийн зөвлөл бөгөөд удирдах ажил гүйцэтгэх үүрэгтэй,

2. Эдийн засгийн хүчин чадал, нутгийн хөгжлийн онцлог тодорхойлсон боловсронгуй механизм бий болгох нь интеграцийн гол хөшүүрэг гэж үздэг.

II. Ази, Номхон далайн бүсийн эдийн засгийн үйл явцад оролцох нь Саха улсын стратегийн гол зорилго мөн. Энэ нь ОХУ-ын Азийн бодлоготой нийцэж байгаа бөгөөд тус улсыг дэлхийн эдийн засгийн харилцаанд интеграцчлах явдалтай холбоотой. Үүний тулд АНДБ-ийн олон улсын байгууллагуудын хамтын ажиллагаанд идэвхитэй оролцох явдал бөгөөд Ази, Номхон далайн бүсийн хамтын ажиллагааны асуудал эрхэлсэн ОХУ-ын үндэсний хороотой (РНКТЭС) хамтран ажилладаг. Энэ нь ЗХА-д харилцан ойлголцол, эрх тэгш, харилцан ашигтай зарчимд тулгуурласан хамтын ажиллагааны харилцан итгэлцлийн уур амьсгал бий болгоход тус дөхөм үзүүлнэ. Саха улс нь Зүүн хойг Азийн бүс нутгуудийн захиргаануудын холбоо (The Association of North East Asia Regional Governments – NEAR)-ны гишүүн. Тус холбоо нь нийт 6 орны 39 бүс нутгийн захиргаануудаас бүрддэг: Японы (Аомори, Исикава, Киото, Ниигата, Симанэ, Тоттори, Тояма, Фукуй, Хёго, Ямагата мужууд), БНХАУ-ын (Нинся-Хуэйи автономит тойрог, Ляонин, Хэнань, Хармерен, Шаньдун мужууд), Өмнөд Солонгосын (Кангвон-до, Кёнги-до, Кёнсанбук-до, Кёнсаннам-до, Чоллабук-до, Чолланам-до, Чечжу-до, Чунчонбук-до, Чунчоннам-до мужууд, Пусан хот), ОХУ-ын (БН Саха Улс, БН Буриад Улс, Хабаровский болон Приморский хязгаар, Амурская, Иркутская, Камчатская, Сахалинская, Читинская мужууд, Усть-Ордын Буриадын автономит тойрог), Хойд Солонгосын (Хойд Хамген муж болон Расон хот) болон Монгол Улсын Төв, Сэлэнгэ аймгууд ордог. Тус холбоо нь байгуулагдсанаас хойш нийт 5 удаа хурал хийж, 2 жилд 1 удаа уулзалт зохион байгуулдаг. Тус холбоо анх байгуулагдахад Монгол Улсын Төв аймаг гишүүнээр элсэн орсон. Анхны хурал нь 1993 оны 10-р сарын 8-ны өдөр Японы Мацу хотод болж нийт 4 орны 11 захиргааны гишүүн оролцсон. II их хурал нь 1998 оны 10-р сард Японы Тояма хотод, III хурал 2000 оны 9-р сарын 4-5-нд Японы Хёго мужийн Авази арал дээр, IV их хурал 2002 оны 9-р сарын 10-11-нд ОХУ-ын Хабаровск хотод тус бүр болж өнгөрсөн. IV хурал дээр анх удаа Хойд Солонгосын Хамген, Расон хотын төлөөлөгчид оролцож, ОХУ-ын Усть-Ордын Буриадын үндэсний тойрог болон Монгол Улсын Сэлэнгэ аймаг

шинээр элсэн орсон онцлогтой. V хурлын бэлтгэл ажилтай холбоотой 2004 оны 1-р сарын 12-14-нд Харбинд болсон Гүйцэтгэх хорооны IV хурал дээр тус байгууллагын зохион байгуулалтын асуудал болон холбооны хэмжээнд хил орчмын хамтын ажиллагааны тусгай хороо байгуулах тухай яригдсан. 2005 оны 9-р сарын 7-нд V хурал Харбинд болсон. Тус хурал дээр олон улсын соёлын харилцаа, байгаль орчныг хамгаалах, худалдаа, эдийн засгийн салбарт хамтран ажиллах асуудлаар хэлэлцсэн. Энэ хурлын үеэр ОХУ-ын Амурын мужийн амбан захирагч Л.Коротков нь Монгол Улсын Сэлэнгэ аймгийн даргатай уулзаж, цаашид хамтран ажиллах чиглэлүүдийг тодорхойлж, аялал жуулчлал, худалдаа, ургамал аж ахуй, ой модны салбарт хамтран ажиллах тухай гэрээ ирээдүйд байгуулахаар тохиролцов. Мөн Л.Коротков нь Хармөрөн мужийн даргатай хэлэлцээ хийсний үр дүнд ойрын үед Амурын мужид олон улсын ЭЗЧБ байгуулах протоколд гарын үсэг зурах тухай харилцан тохиролцоонд хүржээ. Саха улсын Ажил хэрэг, аялал жуулчлал хөгжүүлэх, хөдөлмөрийн яамны сайд А.Скрыбыкин болон Хармөрөн мужийн “Орос тосгон” компанийн захирал Чжао И Чунь нар аялал жуулчлалын объект байгуулах тухай гэрээг тус улсад 2005 оны 12-р сард хийсэн сайдын айлчлалын үеэр үзэглэв.

2006 оны 3-р сарын 13-нд Агинское тойргийн төвд Буриадын Агийн үндэсний тойрог, БН Буриад Улс болон Буриадын Усть-Ордын үндэсний тойргуудын холбооны XI хуралдаан болж өнгөрсөн. Энэ хуралдаанд Оросын тус 3 субъектуудаас гадна БН Саха (Якут) Улс, Чит мужийн парламентын төлөөлөгчид, мөн Монгол Улсын Дорнод аймаг болон БНХАУ-ын ӨМӨЗО-ны Манжуур хотын захиргааны төлөөлөгчид тус тус оролцов. Тус уулзалтын зорилго нь “Байгалийн өвөр болон Байгалийн ар газарт аялал жуулчлал хөгжүүлэх орчин үеийн байдал болон хэтийн төлөв” сэдвээр хамтран ажиллах тухай асуудлуудаар хэлэлцэв. Тус бүсийн газар зүйн байршил нь гадаадын болон дотоодын аялагч жуулчдын анхаарлыг ихэд татдаг бөгөөд олон тооны бааз төвлөрч ирээдүйд эдийн засгийн ашигтай салбар болох бүрэн үндэс бий гэж үздэг. Үүний тулд тус бүс газруудын оюуны, санхүүгийн болон зохион байгуулалт-удирдлагын нөөцийг нэгтгэж, аялал жуулчлалын өргөн үйлчилгээ явуулах хэрэгтэй. Хуралдаанд оролцогчид ОХУ-ын субъектуудын болон Монгол Улс, БНХАУ-ын хил залгаа бүс нутгуудын аялал жуулчлалын холбоо байгуулах тухай санал гаргаж, юуны тулд ажлын бүрэлдэхүүнийг томилж, аялал жуулчлалын нэгдмэл орон зайг бий болгох, нэгдмэл сан байгуулах талаар бэлтгэл ажил эхлэх тодорхой санал дэвшүүлжээ. Мөн үндэсний онцлог хадгалсан ардын

урлаг, дурсгалт зүйлс бүтээхэд дэмжих, үүнийгээ Оросын болон гадаадын аялал жуулчлалын зах зээл дээр хамтран сурталчлахаар тохиролцов. Хоёр дахь хэлэлцэх тулгамдсан асуудал нь “Хөдөөгийн оршин суугчдыг төрийн бус тэтгэврээр хангах тухай” байсан бөгөөд Саха улсын Ил Түмэн улсын хурлын гишүүн, “Эрэл” төрийн бус тэтгэврийн сангийн гүйцэтгэх захирал Ф.Ю.Луковцев үг хэлэхдээ тус байгууллага нь хөдөөг хөгжүүлэх нийгэм-эдийн засгийн ерөнхийлөгчийн хөтөлбөрийн дагуу даатгалын үйл ажиллагаа явуулах Саха улсын Засгийн газрын бүрэн төлөөлөгч мөн бөгөөд тус сан нь 10 жил амжилттай ажиллаж нийт 23 мянган хуулийн этгээд болон 404 байгууллагад үйлчилгээ үзүүлж, түүний дотор 15 мянган хөдөөний оршин суугчид болон 127 хөдөө аж ахуйн байгууллага ордог. Мөн энэ үеэр Агийн тойргийн Дум нь Саха улсын Ил Түмэн улсын хурал болон Монгол Улсын Дорнод аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралтай хамтран ажиллах гэрээнд гарын үсэг зурав. Тус гэрээнд Саха улсаас Ил Түмэн улсын хурлын орлогч дарга А.Н.Ким-Кимэн, Дорнод аймгаас Ц.Шинэбаяр нар тус тус гарын үсэг зуржээ.

Дүгнэлт

Ингэснээр Монгол Улс болон Оросын субъектуудтай хамтын ажиллагаа явуулах тус бүс нутгийн интеграцлалтай холбоотой шинэ нөхцлүүд бүрдэж байна. Өнөөдрийн хувьд Монгол Улс, Саха улсын хувьд шууд эдийн засгийн харилцаа гэхээс бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагуудын хэмжээнд харилцаа илүү хөгжих хандлага ажиглагдаж байна. Мөн нэг тодорхой хүчин зүйл болох ОХУ-ын эрчим хүчний бодлогын хэрэгжилтээс тус бүс нутгийн уур амьсгал, орчин ихээхэн хамаарах бөгөөд тус бүс нутгийн эдийн засгийн хамтын ажиллагаанд нөлөөлөх нь гарцаагүй. Энэ үүднээс авч үзэхэд Саха улс нь Ковыктинскийн орд газраас татаж буй хий, газрын тосны хоолойд залгагдах маш их сонирхолтой бөгөөд энэ нь Орос улсын АНДБ-ийн эдийн засгийн процесст оролцох мөн Саха улсын стратегийн гол зорилготой шууд холбоотой билээ. Тус субъектын хий, газрын тосны хоолойн ашиглалтын урт нь 1818 км, 2002 байдлаар 1.2 сая.тн хий, 95.6 мянган тн газрын тос дамжуулсан байна. Мөн Саха нь Оросын хамгийн том, хүчирхэг, эдийн засгийн хөгжил өндөр, хүмүүсийн амьжиргааны түвшин өндөр, баян чинээлэг БНУ бөгөөд бие даасан гадаад хамтын ажиллагаа хөгжүүлдэг субъект гэж үздэг. Жишээлбэл, Сахагийн томоохон алт, алмазын “АЛПРОСА” үйлдвэрийг холбооны удирдлагад

шилжүүлэх маргаан бүрэн шийдвэрээ олоогүй байна. Мөн дээр дурьдснаар, энэ субъект нь ОХУ-ын нийт хүн амын дөнгөж 8 хувийг эзэлдэг бөгөөд нийт ҮНБ-ий 20 хувийг дангаар үйлдвэрлэдэг. Умардын чуулганы хамтын ажиллагааны хүрээнд шинэ агаарын нислэгийн шугам нээгдсэнээр субъектуудад ашигтай төдийгүй, Оросын төсөвт урьдчилсан тооцоогоор нэг жилд 180 сая ам.долларын ашиг оруулах тооцоо бий. Мөн ЮНЕСКО-гийн клубуудын холбооны хамтын ажиллагааны үр дүнд якут оюутан, сурагчид гадаадад явж, олон улсын залуучуудын байгууллагуудын хэмжээнд зуны улиралд гадаадад амардаг болсон. Үүний дотор Монголын олон улсын залуучуудын “Торгон замын тууль” лагерьт ирж амардаг. Энэ нь тэдгээрийн олон улсын мэдлэг, соёлын туршлага баяжуулж байна гэж үздэг. Иймээс эдийн засгийн бүх салбарт, ялангуяа аялал жуулчлал, түүний дотор зуны амралт, экотуризм хөгжүүлэх үүднээс, тус улстай хамтын ажиллагаагаа хөгжүүлэх нь чухал байна. Монголын онгон цэвэр байгаль, экологийн цэвэр бүтээгдэхүүнийг сурталчилж, махны экспортыг хөгжүүлэхэд анхаарах хэрэгтэй байна.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

1. http://stat.sakha.ru/pernas/osn_itog_vpn_2002.asp/, http://www.perepis2002.ru/ct/grf_map.htm ОХУ – ын субъектуудын дотор хүн амын тоогоор 58 – р байр эзэлдэг.
2. <http://justit.ru/encyclor/0/013103> Энциклопедия / ЯКУТЫ
3. Федеративный договор о разграничении предметов ведения и полномочий между Россией и субъектами Федерации.
4. Внешние связи Республики Саха (Якутия): проблемы и перспективы. Александр Мигалкин.
5. Договор о разграничении предметов ведения и полномочий между органами государственной власти Российской Федерации и органами государственной власти Республики Саха (Якутия).
6. Соглашение между Правительством Российской Федерации и Правительством Республики Саха (Якутия) о разграничении предметов ведения и полномочий в области международных и внешнеэкономических связей.
7. Департамент по связям с субъектами Федерации, парламентом и общественно-политическими организациями (ДСПО) МИД РФ
8. Главное управление координации внешнеэкономической деятельности субъектов Федерации МВЭС РФ.
9. ГУП “Комитет по драгоценным металлам и драгоценным камням РС /Я/”.